



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 9/277

Мандалговь

Г Ашигт малтмал тээвэрлэлтийн
чиглэл батлах тухай Г

Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гурвансайхан сумын нутагт орших Цагаан тээгийн гантигийн уурхайгаас Говьсүмбэр аймаг хүртлэх 184 км ашигт малтмал тээвэрлэлтийн автозамын чиглэлийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан чиглэлийн дагуух орон нутгийн чанартай авто замыг арчилж хамгаалан, замын тэмдэглэгээ байрлуулж, маршрутын дагуу тээвэрлэлт явуулж байхыг "Үнэн бэх" ХХК-ийн захирал (LI YONG SHENG) -д үүрэг болгосугай.

Гурав. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хүрээнд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлт явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Авто тээврийн төв (Ц.Бямбацогт), Цагдаагийн газар (О.Амарсанаа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2019 оны 07 сарын 30
өдрийн 177 тоот захирамжийн хавсралт

ГУРВАНСАЙХАН СУМЫН ЦАГААН ТЭЭГИЙН ГАНТИГИЙН УУРХАЙГААС
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ХҮРТЭЛХ 184 КМ АВТО ЗАМЫН ЧИГЛЭЛИЙН СОЛБИЦОЛ

№	Байршил	Уртраг	Өргөрөг
1	Цагаан тээг уурхай	107 09 17,6	45 17 42,6
2		107 13 40,5	45 14 42,6
3		107 15 22,6	45 14 37,4
4		107 18 32,9	45 13 17,9
5		107 26 33,9	45 19 22,9
6		107 29 37,2	45 22 43,6
7		107 48 57,8	45 35 50
8	Баянжаргалан сум	107 58 54	45 45 7,7
9		108 00 47	45 50 44,3
10		108 05 09	45 54 4,8
11		108 15 20,8	46 06 45,5
12		108 15 23,4	46 10 8,5
13		108 19 4,4	46 14 53,7
14		108 18 31	46 16 31,4
15	Чойр	108 21 41,1	46 22 10,6